



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
“10 АЙМГИЙН ТӨВИЙН
ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ”
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ**

17040 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Айбиз Стайлез Улаанбаатар,
Оффисын хэсэг, 7-р давхар. Утас: 7000 1196
Цахим шуудан: info-10aimag@energy.gov.mn

2022.12.14 № А/264
танай _____-ны № _____-т

Г БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН
БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Г Хүсэлт хүргүүлэх тухай Г

БНСУ-ын “Экспорт Импорт” банкны хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтээр Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгийн төвд иж бүрэн дулааны станц, дулаан дамжуулах шугам сүлжээ, дулаан дамжуулах төвийг барих төсөл хэрэгжиж байна.

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлыг “Эко трейд” ХХК гүйцэтгэж, тайланг 2019 оны 08 дугаар сарын 30-ний өдөр “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар батлуулсан байдаг.

Төсөл хэрэгжиж буй 10 аймгийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ийн дагуу боловсруулсан төслийг үүгээр хүргүүлж байна.

Иймд энэхүү төлөвлөгөөний төслийг хүлээн авч, холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хавсралт ... хуудастай.

Хүндэтгэсэн,

ЗОХИЦУУЛАГЧ

Ж.МЯГМАРСҮРЭН



000682

БАТЛАВ.

БОАЖЯ-ны ХБОБНУГ азрын дарга

Г.Энхмөнх

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВД ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ ТӨСӨЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН

2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГ ЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“10 АЙМГИЙН ТӨВИЙН ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ”
ТХН-ийн зохицуулагч Ж.МЯГМАРСҮРЭН



ХЯНАСАН:
ХБОБНУГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:
ТХН-ийн БО-НЫ МЭРГЭЖИЛТЭН Д.БАТХУЯГ

2022 ОН

Агуулга

Оршил.....	1
Танилцуулга.....	4
1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	8
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	9
3. Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө	16
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө.....	17
5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	17
6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
6.1 Баримтлах эрх зүйн баримт бичиг	19
7. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)	22
8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	25

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 2.1: Арвайхээр хотод 30 гКал/цаг хүчин чадалтай дулааны станц, шугам хоолой барьж аишглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл	9
Хүснэгт 2.2: Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө.....	10
Хүснэгт 3.1: Дулааны станцын барилга байгууламжийн талбай	16
Хүснэгт 3.2 Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө	16
Хүснэгт 5.1: Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	18
Хүснэгт 6.1: Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 7.1: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
Хүснэгт 8.1: Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	26

Зургийн жагсаалт

Зураг 1: Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 459 дугаар тогтоол	2
Зураг 2: Төслийн байршил	5
Зураг 3: Аймгийн Засаг даргын газар эзэмшүүлэх захирамж, кадастрын зураг	6
Зураг 4: Арвайхээр хотод төлөвлөгдсөн шугам сүлжээний зураглал	17

Оршил

Монгол орон нь дэлхийн хамгийн хүйтэн орнуудын нэг бөгөөд одоо ашиглаж байгаа дулаан хангамжийн систем нь орон нутгийн иргэдийн ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой боловч энэхүү төслийн зорилтот газар болох 10 аймгийн төвд байгаа дулаан хангамжийн тоног төхөөрөмж хуучирч муудсан бөгөөд дулаанаар хангах чадал нь хүрэлцэхгүй, байгаль орчинд гаргах хорт хаягдал өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа. Ийм ч учраас хэрэглэгчдийн зүгээс олон тооны гомдлууд ирдэг бөгөөд цаашид үргэлжлүүлэн, хэвийн ажиллуулах боломжгүй юм. Үүнд:

- Зуухны ашигт үйлийн коэффициент < 40%
- Ашиглалтын ажиллагаа болон чадал хангалтгүй
- Ахуйн хэрэглээний халуун усны систем шаардлага хангахгүй, огт байхгүй
- Байгаль орчны бохирдол маш их
- Ажиллах орчны нөхцөл муу
- Технологи бүрэн бус

Энэхүү 10 аймгийн төвд байгаа дулаан хангамжийн системийн хангалтгүй байдалтай холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 459 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл тухай” хэсгийг үндэслэн Эрчим хүчний яамны “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”-ийг 2019 онд байгуулсан.

- 10 аймгийн төвд шинээр дулааны станц ба дулааны шугам сүлжээ барих.
- Байгал орчинд ээлтэй зуухны технологи сонгон авч, аймаг бүрд байнгын ажиллагаатай дулааны станц барих.
- Дулааны станц ба дулааны шугам сүлжээг үр ашигтай ашиглах, үйлчилгээ явуулах нэгдсэн бодлого боловсруулах.

Өвөрхангай аймаг нь Монгол улсын төв хэсэгт Архангай, Булган, Баянхонгор, Төв, Дундговь, Өмнөговь аймгуудтай хиллэдэг. Газар зүйн байрлалаар далайн түвшнээс 1813 метрт өргөгдсөн, 102 градус 47 минутын уртраг 46 градус 16 минутын өргөрөгт оршино. Арвайхээр хот нь 10 багийн 9395 өрх, 32477 хүн амтай бөгөөд 173 км² талбайг эзлэн, нийслэл Улаанбаатар хотоос өрнө зүгт 431 километр зайд байрлана.

Арвайхээр хотын 2018 оны агаарын чанар

SO ₂ , (мг/м ³)	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	0.041	0.031	0.019	0.008	0.02	0.022	0.037
NO ₂ , (мг/м ³)	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	0.05	0.044	0.042	0.017	0.034	0.028	0.036
CO, (мг/м ³)	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	2.8	2.6	1.69	1.54			
PM ₁₀	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
	0.219	0.137	0.095	0.064	0.054	0.112	0.177



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 459

Улаанбаатар
хот

Зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл
хөрөнгөөр хэрэгжүүлэх
төслийн тухай

Өрийн удирдлагын тухай хуулийн 9.1.20, 9.1.21-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2011-2015 онд авах зээлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр"-ийн хүрээнд авах зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл болох 244.5 (хоёр зуун дөчин дөрвөн сая таван зуун мянган) сая ам.долларын хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан төслүүдийг Солонгосын талд санал болгохыг Сангийн сайд Б.Болор, төслийг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн сайд М.Зоригт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Хууль зүйн сайд Д.Дорлигжав, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт тус тус даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Б.БОЛОР

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНГААС 2011-2015 ОНД
АВАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ
СОЛОНГОС УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ЕРӨНХИЙ
ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХҮРЭЭНД АВАХ ЗЭЭЛИЙН
АШИГЛАГДААГҮЙ ҮЛДЭГДЭЛ ХӨРӨНГӨӨР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

№	Төслийн нэр	Төсөвт өртөг (сая ам.доллар)
1	Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл (300 автобус)	30.5
2	Ухаалаг боловсрол төсөл	20.0
3	Харгиа урьдчилсан цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл	20.0
4	10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл	130.0
5	Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл	19.0
6	Шүүх шинжилгээний байгууллагын чадамжийг сайжруулах төсөл	13.5
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын цахим хяналтын систем байгуулах төсөл	9.5
8	Хууль сахиулах их сургуулийн төв байрны сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл	2.0
	Нийт	244.5

Танилцуулга.

Төслийн нэр: Монгол Улсын “10 аймгийн төвийн дулааны станц барих” төсөл
(Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 459 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл тухай” хэсгийг үндэслэн Эрчим хүчний яамны “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”-ийг 2019 оны 04 дүгээр 23-ны өдөр байгуулсан.)

Захиалагч: Эрчим хүчний яам

Зээлийн дугаар : MON-14

Хэрэгжүүлэх байгууллага: “10 аймгийн төвийн дулааны станц барих” төсөл хэрэгжүүлэх нэгж

Регистрийн дугаар: 8313628

Улсын бүртгэлийн дугаар: 9068001029

Утас: +976-70001189, 88077925

Хэрэгжүүлэгч байгууллага үйл ажиллагааны чиглэл:

- “10 аймгийн төвд дулааны станц барих”

Хэрэгжүүлэгч байгууллагын хаяг: Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын 14 байр,

Төслийн зорилго:

- Төвлөрсөн дулаан хангамжтай дулааны станц шинээр барих
- Дулааны станцын үр ашгийг дээшлүүлэх
- Өсөн нэмэгдэж буй хэрэгцээнд нийцүүлэн дулааны станцыг өргөтгөх
- Жилийн турш хэрэглээний халуун усаар тасралтгүй хангах
- Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулах
- Ажлын нөхцлийг сайжруулах

Төслийн зорилт: Монголын хэрэглэгчдийн амьдралын стандартыг дээшлүүлэх хүрээнд дараах зорилтуудыг тавьсан.

- Дунд болон урт хугацааны үр дүн
 - Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.
 - Үйлдвэрийн аваар ослыг бууруулна.
 - Агаарын бохирдлыг бууруулна: SOx / NOx / Тоосонцор
 - Ахуйн хэрэглэгчдийн дундах эрчим хүчний тэгш бус байдлыг арилгана.
- Богино хугацааны үр дүн
 - Дулааны станцын ашиглалтын түвшин дээшилж, агаарын чанар сайжирна.

- Дулаан хангамжийг тасралтгүй явуулж, хүрэлцээ муутай газрууд үгүй болно.
- Ахуйн хэрэглэгчдийн аюулгүй байдал болон орчин сайжирна.

Төслийн зөвлөх үйлчилгээний гүцэтгэгчийн хувьд Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Экспорт-Импортын банк хооронд байгуулсан Зээлийн гэрээний хүрээнд “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”-ийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч болох “Кориан дистрикт хийтэнг инженеринг корпорэшн” -тай 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдөр холбогдох гэрээ байгуулж, албан ёсоор зөвлөх үйлчилгээг эхлүүлсэн.

Төслийн байршил. Төсөл хэрэгжүүлэх талбай нь засаг захиргааны нэгжийн зорилтот 10 аймгийн төв хамаарагдана. Улаанбаатар хотын төвөөс 1000 гаруй км зайд орших аймгийн төвийн иргэдийн амьдрах, ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлэх төдийгүй, төсөл хэрэгжсэнээр дулааны станцын байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бодитой бууруулсан байх юм. Эдгээр төвийн хуучирч муудсан дулааны үйлдвэрлэх, хангах системийг төслөөр сайжруулж шинэчилнэ.

- Төв (Зуунмод)
- Дундговь (Мандалговь)
- Хэнтий (Чингис)
- Өвөрхангай (Арвайхээр)
- Говь-Алтай (Алтай)
- Завхан (Улиастай)
- Архангай (Цэцэрлэг)
- Баянхонгор (Баянхонгор)
- Говьсүмбэр (Чойр)
- Сүхбаатар (Баруун-Урт)

Төслийн хүрээнд хийгдэх бүх ажил 10 аймагт нэгэн зэрэг явагдана. Дулааны станцуудын геологийн судалгаа, талбайн төлөв байдлын судалгааг нарийвчилсан зургийн үед нэгэн зэрэг хийж гүйцэтгэнэ.



Зураг 2 Төслийн байршил



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 06

Дугаар А/320

Архайсан

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэр Од хотхон 7 дугаар цэцэрлэгийн баруун урд 150м², 8 дугаар багийн нутаг дэвсгэр Рашаант хотхон 8 дугаар цэцэрлэгийн зүүн урд 150м² газрыг дулаан дамжуулах төвийн барилга байгууламжийн доорх газрын зориулалтаар Эрчим хүчний хөгжлийн төвд 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 06 дугаар захирамжийн Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газарт 5 дугаар багийн нутаг дэвсгэрт журмын хашааны баруун урд 3300м² газрыг цэцэрлэгийн зориулалтаар эзэмшүүлэх тухай заалтыг 3163.5м² болгон талбайн хэмжээнд өөрчлөлт оруулсугай.

3. Газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



02 1093

D:My Doc. Zahiramj Zasag darga

Аймгийн Засаг даргын 2016 оны...
дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

Дулаан дамжуулах төвийн байршил, хэмжээ

Д/д	Газрын зориулалт, ДДТөвийн дугаар	Газрын хэмжээ /м2/	Дулаан дамжуулах төв баригдах газрын байршил, хаяг
1	Дулаан дамжуулах төв 1	216	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хашааны залгаа хойно
2	Дулаан дамжуулах төв 2	216	4-р цэцэрлэгийн хашааны баруун урд, Өв-Илч ХХК-ийн зүүн талд
3	Дулаан дамжуулах төв 3	216	БОЭТ-ийн халаалтын зуухны баруун хойно
4	Дулаан дамжуулах төв 4	156	МХСүлжээ ТӨХК-ийн урд /Иргэн Ө.Насанжаргалын эзэмшил газрын баруун хойно/
5	Дулаан дамжуулах төв 5	216	Ерөнхий боловсролын 2-р сургуулийн зүүн талд
6	Дулаан дамжуулах төв 6	216	Ерөнхий боловсролын 4-р сургуулийн баруун, "Дэлгэрэх хүнс" ХК-ийн үйлдвэрийн хашааны урд
7	Дулаан дамжуулах төв 7	216	МСҮТ-ийн халаалтын зуухны баруун талд
8	Дулаан дамжуулах төв 8	216	5 дугаар баг Арвай-Илч ХХК-ийн халаалтын зуухны зүүн талд
9	Дулаан дамжуулах төв 9	216	ЕБ-ын Мэргэд цогцолборын сургуулийн спорт заалны зүүн урд, "Хөтөлт-Илч" ХХК-н хашааны хойно
10	Дулаан дамжуулах төв 10	216	5 дугаар баг 4-р гудамж 461-р байрны зүүн талд

--- ооо ---

ХУУЛБАР ҮНЭМ
Газрын үсэг: 2018.01.01 сар 19

Зураг 3 Аймгийн Засаг даргын газар эзэмшүүлсэн захирамж, кадастрын зураг

1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь тухайн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, бохирдлоос сэргийлэх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдсэн.

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод баригдах 30 гКал хүчин чадалтай, дулааны станц, шугам хоолой, түгээх төвүүдийг барьж ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг БОАЖЯ-ны 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн тоот бүхий Дулааны станц, дулаан дамжуулах шугам сүлжээний төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагууд дээр үндэслэн тодорхойлов. Мөн 2012 онд УИХ-аар хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамал хамгааллын тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай болон 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай зэрэг хуулиуд, түүнтэй холбогдон бусад хуулиудад орсон өөрчлөлтүүд ялангуяа аж ахуйн нэгж, байгууллагын байгаль хамгаалах талаар хүлээх үүргийг тусгасан болно.

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

2018 онд батлагдсан 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан байгаль орчны бүрдэл хэсгүүд бүрт тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг тус бүлэгт хэрэгжүүлэх хугацаа, үндэслэл, баримтлан ажиллах дүрэм, стандартууд, зардлын хамт оруулав.

Төслийн хувьд барилга угсралтын ажил эхэлж ойролцоогоор 24 сарын турш үргэлжлэн, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн тул нөхөн сэргээлт, орчны тохижилттой холбоотой ажлуудыг 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаагүй, гэхдээ дээрх чиглэлийн ажил үйлчилгээг огт хэрэгжүүлэхгүй гэсэн ойлголт биш юм. Тус төслийн 2023 онд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардал 1,903,000 төгрөг бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зардал өсөж болно. Тухайн жилийн БОМТ-г барилгажилтын үе шатанд барилга угсралтын ажлын гүйцэтгэгч байгууллага хэрэгжүүлнэ.

Хүснэгт 2.1: Арвайхээр хотод 30 гКал/цаг хүчин чадалтай дулааны станц, шугам хоолой барьж аишглах төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгтгэл

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	1,253,000
2	Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын зардал	-
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	650,000
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	-
Нийт дүн		1,903,000

Хүснэгт 2.2: Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Тайлбар /Үндэслэл/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Газрын гадарга бохирдох	Дулааны станцын барилгын ажлыг эхлүүлэхээс өмнө тус үнэлгээний тайлангийн хог хаягдлын хэсэгт заасны дагуу "Хог хаягдлыг дахин ашиглах, зайлуулах, төлөвлөгөө" боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах шаардлагатай. Дулааны станцын талбайн ойролцоо хог хаягдал түр хадгалах цэг байгуулан, хадгалах, тусгай зөвшөөрөлтэй төвлөрсөн хогийн цэгрүү тээвэрлэх шаардлагатай.	Дулааны станцын барилгын ажилд ашиглаж байгаа талбай	Удаа	-	-	-	Хог хаягдлын менежментийн хэсэгт тусгасан.	Хог хаягдлын тухай хууль, 2017 он, 10 дугаар бүлэг
	Барилгын ажилд ашиглаж байгаа тээврийн хэрэгслүүдийг тогтсон нэг зогсоолд байрлуулах, тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоог тогтмол хийж байх, тос масло асгарсан тохиолдолд хамгаалах, саармагжуулах арга хэмжээ авах	Барилгын ажлын үед ашиглаж байгаа тээврийн хэрэгсэл	Удаа	-	-	-	Хөрсний хэсэгт тусгасан.	-
	Шугам хоолойн барилгын ажлыг гүйцэтгэхдээ Засгийн газрын 1996 оны 120 дугаар тогоолын 1 дүгээр хавсралт "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийг	Нэгдүгээр хэлхээний шугам хоолой барих үед 36728.0 м ² талбайн газрын гадарга	Га	-	-	-	Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын ажлын зардалд тусгах	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Тайлбар /Үндэслэл/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
	баримтлан ажиллах, шугам хоолойн газар шорооны ажлын үед хөрс, газрын гадарга бохирдуулахгүй байх тал дээр анхааран ажиллах, газар шорооны ажил дууссаны дараагаад тухайн орчны гадаргын төрх байдалд дөхүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх хэрэгтэй.							
Хэсгийн дүн								
ХОЁР.УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Дулааны станцаас жилд дунджаар 90,127 тн CO ₂ ялгарснаар агаар мандал дахь хүлэмжийн агууламжийг нэмэгдүүлэх	Бүрэн шаталттай, өндөр үр ашигтай зуух ашиглахаар төлөвлөсөн.	Дулааны станцад				Үйл ажиллагааны зардалд тусгах		Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06)
Хэсгийн дүн								
ГУРАВ. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Дулааны станцыг барих, түүхий эдийг зөөвөрлөх үйл ажиллагаанаас тоосжилт үүсэж, агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Дулааны станцын барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замуудад шаардлагатай тохиолдолд усалгаа хийж байх	Дулааны станцын талбай, нүүрс тээвэрлэх зам	удаа	-	-	-	Нэгж талбайг услах зардлыг тооцсон бодит үр дүнгээс үнийг тогтоох, мөн цаг уурын нөхцөл байдалтай уялдуулан арга хэмжээ авах тул шууд тооцох боломжгүй.	Монгол улсын Агаарын тухай хууль; MNS 4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага
Дулааны станцын	Ашиглаж байгаа техник	Дулааны	удаа	-	-	-	Агаарын	Агаарын

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Тайлбар /Үндэслэл/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
барилгын ажлын үед болон ашиглалтын үед ашиглах техникүүдийн яндангаас бохирдуулагч ялгарах	хэрэгслүүдэд тогтсон хугацаанд хяналт хийх ба шаардлага хангахгүй байгаа төхөөрөмжүүдийг ашиглалтаас хасах, агаар бохирдуулсны төлбөр төлөх	станцын талбай, нүүрс тээвэрлэх зам					бохирдлын төлбөрийн тухай хууль, 7.3. тогтооно.	бохирдлын төлбөрийн тухай хууль

Хэсгийн дүн

ДӨРӨВ. ГАДАРГЫН УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Тээврийн хэрэгслээс ШТМ асгарах, дулааны станцын яндан, нүүрсний агуулах, үнс хадгалах байгууламжаас үүссэн тоос, дэгдэмхий үнсээр хөрсөн бүрхэвч бохирдож, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын усыг бохирдуулж болзошгүй.	ШТМ асгарсан тохиолдолд тархахаас сэргийлж зориулалтын шингээгч материал (spill kit)-ыг тээврийн хэрэгслүүдэд болон бусад шаардлагатай газруудад бэлэн байлгах	Тээврийн хэрэгслүүдэд болон бусад шаардлагатай газруудад				Хөрсний БОМТ-ийн зардал тусгасан.		
	Үнс хадгалах байгууламж нь битүүмжлэл сайтай, үнсийг зориулалтын автоцистернд ачих технологитой байх	Үнс хадгалах байгууламж				Үйл ажиллагааны зардалд тусгах		

Хэсгийн дүн

ТАВ. ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Дулааны станцын үйл ажиллагаанд цагт 118.2 м³, хоногт 2836.8 м³, жилд 1,035,432 м³, 5 жилд 5,177,160 м³ усыг технологийн хэрэгцээнд ашиглах урьдчилан тооцоолол гарсан байна. Энэ хэмжээгээр газрын доорх усны нөөцөд нөлөөлнө.	Технологийн хэрэгцээнд ашиглаж байгаа усны хэрэгцээг багасгахын тулд усыг үр ашигтай хэрэглэх ба усны хэрэглээ багатай техник технологийг сонгон ашиглах	Дулааны станцыг барьж ашиглах	-	-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан.	Усны тухай хууль, 2012, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012
	Ус ашигласны төлбөр төлөх		м³/төг	-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан.	Усны тухай хууль, 2012, Байгалийн нөөц ашигласны

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Тайлбар /Үндэслэл/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Барилгын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс алдагдсан шатах, тослох материал угаагдаж, хур борооны үерийн усаар, зөөгдөн хөрсөн бүрхэвч бохирдох, улмаар гадаргын болон газрын доорх усны чанар, найрлагад нөлөөлж болзошгүй	Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчинд авах арга хэмжээг хэрэгжүүлэх	Дулааны станцын талбай	-	-	-	-	төлбөрийн тухай хууль, 2012	
Хэсгийн дүн								-
ЗУРГАА. ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Дулааны станц, дулаан дамжуулах шугам болон дулаан дамжуулах төвүүдийг барих явцад нийт 4.05 га талбайгаас нийт 0.96 тн ялзмагийн нөөц бүхий 8080 м ³ үржил шимт хөрс хуулагдаж, эвдэрнэ.	Барилгын ажил эхлэхийн өмнө эвдэгдэх талбайн шимт хөрсийг 0.2 метр зузаантайгаар хуулан авч дулааны станцын эзэмшил газарт шимт хөрсний овоолгын талбайд хадгалан, нөхөн сэргээлтийн ажилд эргүүлэн ашиглана.	Дулааны станц, дулаан дамжуулах төвүүд болон дулааны шугам сүжлээний хоолойг барих явцад эвдрэх 4.05 га талбай, түүний орчим					Үйл ажиллагааны зардал	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт (MNS 5916:2008)
	Шимт хөрсний овоолгыг нөхөн сэргээлтэнд ашиглахаас өмнө дээж авч шинжлүүлсэний дараагаар ашиглана.	Үржил шимт хөрсний овоолго	Төг/уда а	40,000	3	(120,000)	Зардлыг ОХШХ-т багтаасан	

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Тайлбар /Үндэслэл/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
Тээврийн хэрэгслүүд болон ШТС-аас ШТМ асгарсан тохиолдолд орчны хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй.	ШТМ шингээх зориулалтын материал (Spill Station Oil & Fuel Spill Kit)-ыг бэлэн байлгаж ШТМ асгарсан тохиолдолд ашиглан тархалтыг хязгаарлах	Тээврийн хэрэгслүүд, бусад хэрэгцээтэй газруудад	Төг/жил	400,000	5	(2000,000) Үйл ажиллагааны зардал	Асгаралтыг шингээж авах иж бүрдэл (spill kit)	https://www.spillsupplies.com.au/oil-spill-kits-c18
Барилгын материал, тоног төхөөрөмжүүдийг тээвэрлэх, барилгын ажлын явцад олон салаа зам үүсэж, хөрсөн бүрхэвч эвдэрч болзошгүй.	Тээврийн хэрэгслүүдийг зөвхөн засварын газарт урсгал засварыг хийлгэнэ.	Барилгын болон ашиглалтын үед ашиглаж байгаа бүх тээврийн хэрэгслүүд				Үйл ажиллагааны зардал		
Барилгын материал, тоног төхөөрөмжүүдийг тээвэрлэх, барилгын ажлын явцад олон салаа зам үүсэж, хөрсөн бүрхэвч эвдэрч болзошгүй.	Барилгын материал, тоног төхөөрөмжүүдийг зөвөөрлөх тээврийн хэрэгслүүд авто замын нэгдсэн сүлжээгээр зорчино. Шинээр түр замууд үүссэн тохиолдолд хааж байгалийн аясаар нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Шинээр түр авто замууд үүссэн тохиолдолд	Төг/жил	500,000	3	Үйл ажиллагааны зардал 1,500,000	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль"-ийн 7.2.3 барилга байгууламж барьж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь барилгын ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх	
Хэсгийн дүн								
ДОЛОО. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Барилгажилтын үе: Жижиг хөхтөн амьтад, тэдгээрийн нүх, оромж нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгажилтын явцад амьтад устахаас урьдчилан сэргийлж, газар хөндөлтийн өмнө амьтад өртөх эсэхийг шалгах, амьтдыг эрсдэх орчноос үргээж холдуулах	Дулааны станц, 9,182 м шугам хоолой, дулаан дамжуулах 11 төвийг байгуулахад өртөх 4.04 га		Гүйцэтгэгчийн үйл ажиллагааны зардал тусгагдана			Гүйцэтгэгчийн үйл ажиллагааны зардал тусгагдана.	дулааны станц, дулаан дамжуулах нэгдүгээр хэлхээний шугам хоолой барьж ашиглах төслийн

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Тайлбар /Үндэслэл/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
		талбай						БОННУ
Биологийн төрөл зүйлийн чухал амьдрах орчны хувьд дулааны хангамжийг сайжруулах төслийн талбайд ойр (0-20 км-т) орших ШЧГ, улсын болон орон нутгийн ТХГН болоод ойн сан байхгүй тул эдгээр амьдрах орчны биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл байхгүй.								
Хэсгийн дүн								
НАЙМ. ФИЗИК БОХИРДОЛ, ДУУ ШУУГИАНААС ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Барилгын ажлын үйл ажиллагаанд ашиглагдах машин техник, тоног төхөөрөмжүүдээс дуу шуугиан үүсэж, төслийн ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй	Үйл ажиллагааны явцад ашиглагдах техник хэрэгслүүдээс гарах дуу шуугианы түвшинг тухайн техник хэрэгслийн үйлдвэрээс зааж өгсөн дуу чимээний техникийн үзүүлэлтээс хэтрүүлэхгүй байх	Дулааны станцын талбай	-	-	-	-	Үйл ажиллагааны зардал	MNS 4585: 2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
ЕС. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Төслийн хүрээнд дулааны эрчим хүчний салбарт ажиллаж буй эмзэг бүлэгт хамаарагдах хүмүүсийн (өрх толгойлсон эцэг эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амжиргааны түвшин доогуур өрх гэр бүлүүд) орлогын эх үүсвэр буурах, санхүүгийн дарамтад орох	Ажилгүй болох хүмүүсийг дахин ажлын байраар хангах, шинээр ажилд зуучлах эсвэл ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамрагдуулж ажилд ороход дэмжлэг үзүүлэх тал дээр анхаарах	Дулаан хангамжийн компанид ажиллаж буй ажилчид	-	-	-	-		МУ-ын 2012 оны 1 сарын 19-нд батлагдсан "Нийгмийн халамжийн тухай" хууль МУ-ын 2012 оны 1 сарын 19-нд батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хууль МУ-ын 2011 оны 6 сарын 17-нд батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хууль МУ-ын 1999 оны 5 сарын 14-нд

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Тайлбар /Үндэслэл/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
								батлагдсан "Хөдөлмөрийн тухай" хууль МУ-ын 2008 оны 5 сарын 22-нд батлагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хууль МУ-ын 2011 оны 6 сарын 17-нд батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хууль
Дулааны эрчим хүчний салбарт ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутмаг байх	Боловсон хүчнийг одооноос практикт суурилсан сургалтад хамруулах, бэлтгэх	Дулааны эрчим хүчний салбарт ажиллах боловсон хүчин	-	-	-	-		МУ-ын 2011 оны 6 сарын 17-нд батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хууль
Төслийн хэрэгжилтийн соёлын өв, дурсгалт газрыг байдлаар эсвэл нөлөөлөх	Барилга, шугам сүлжээний газрын ажлын нөлөөлөлд өртөж болзошгүй хөшөө дурсгалыг хаалт, хучлага хийж хамгаалах; Барилгын явцад түүх дурсгалын зүйлс илэрсэн тохиолдолд ажлыг зогсоож, холбогдох журмын дагуу арга хэмжээ авах.	Аймгийн төвд бүртгэлтэй соёлын өв, түүх дурсгалт зүйлс	-	-	-	-		МУ-ын 2014 оны 5 сарын 15-нд батлагдсан "Соёлын өвийг хамгаалах тухай" хууль
АРАВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ								
Ахуйн хатуу хог хаягдлаар бохирдох	Дулааны станцын барилгын ажлын үе шатанд	Хог хаягдлыг шаардлага	Тн/жил	25000	12.53	1,253,000	Хог тээврийн зардал	

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжи х нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Тайлбар /Үндэслэл/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
		хангасан хогийн цэг байгуулан түр хадгалах						
Нийт дүн						1,253,000		
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал 2023 он						1,253,000		

3. Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө, 2024 он

Дулааны станц, нүүрс хадгалах байгууламж, харуулын байр 0.33 га-д, дулаан дамжуулах 11 төвийг шинээр барихад 0.038 га, дулаан дамжуулах 9,182 метр (4 м өргөн) шугам хоолойг суурилуулахад 3.67 га буюу нийт 4.04 га талбайд дулааны станцын барилга байгууламж, шугам хоолой баригдана (Хүснэгт 3.1).

Хүснэгт 3.1: Дулааны станцын барилга байгууламжийн талбай

Барилгын нэр	Бүтэц	Хэмжээ (м)	Талбайн хэмжээ (м ²)	Талбайн хэмжээ (га)
Дулааны станцын байгууламж	Төмөр	30 x 56	1680	0.168
Нүүрс хадгалах байгууламж		28 x 56	1568	0.157
Харуулын байгууламж 1	Бетонон	4.5 x 4	18	0.002
Харуулын байгууламж 2		3.5 x 2.5	8.75	0.001
Дулаан дамжуулах шугам хоолой		9,182 м (4 м өргөн)	36728	3.67
Түгээх төв (11 шинэ)	Бетон	7 x 9	126	0.013
		7 x 6	252	0.025
Хөрс хуулалт хийх талбай, га				4.04

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.3¹-т заасны дагуу барилгын ажлын явцад болон дууссаны дараа нөлөөлөлд өртсөн газрыг тэгшилж, дулааны станцын барилга хоорондын талбайг тохижуулан, ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна явган хүний зам болон автозамыг хатуу хучилттай болгох шаардлагатай. Нөхөн сэргээлт орчны тохижуулалтаар гүйцэтгэх ажил, баримтлах стандарт, хэрэгжүүлэх хугацаа, холбогдох зардал зэргийг төлөвлөн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3.2 Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлнэ.

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Нэгжийн зардал, төг.	Нийт зардал, төг.	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
Дулааны станцын барилгажилтын үйл ажиллагааны үед нөлөөлөлд өртсөн газрын хөрсийг бэхжүүлж, үржил шимийг нь сайжруулж, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Шимт хөрсөөр хучих талбайн хөрсийг түрж, тэгшлэх	Шимт хөрсөөр хучих талбай	600,000	1,800,000	2024 онд барилгажилтын хугацаанд	MNS 5914:2008 Байгаль орчин: Газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт. MNS 5916:2008 Байгаль орчин: Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, хадгалах. MNS 5918:2008 Байгаль орчин: Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага.
	Хучсан шимт хөрсийг тараан, тэгшилж, байгалийн нөхөн ургалтыг дэмжих	Шимт хөрсөөр хучигдсан талбай	400,000			
Нийт зардал, төг				3,000,000		


¹Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.3. барилга байгууламж барьж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь барилгын ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх;

4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

10 аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийн хүрээнд Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод шинээр дулааны станц, дулаан дамжуулах төвүүд, дулаан болон цахилгааны шугам сүлжээг байгуулна. Төслийн нөлөөлөлд 1 конторын шугам, төлөвлөгдсөн дулаан дамжуулах төвүүд, дулааны станцын ойр орчимд оршин сууж буй айл өрхүүд, үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүд хамрагдана. Судалгааны хүрээнд тус аймагт дулааны станцын төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох айл өрх, хувь хүн, аж ахуй нэгж байхгүй болно. Гэвч төслийн хэрэгжилтийн явцад төслийн хэрэгжилттэй холбоотой үүссэн санал гомдлыг журмын дагуу шийдвэрлэх шаардлагатай.

Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор хувь хүн, аж ахуй нэгжийн эзэмшил газраар дайран өнгөрөх тохиолдолд, шугам сүлжээг байгуулах явцад Монгол улсын Засгийн газрын 1996 оны 120 тогтоолоор баталсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийг баримтлах бөгөөд холбогдох нөхөн олговрыг Эдийн засгийн Хөгжлийн Хамтын ажиллагааны Сангийн Аюулгүй ажиллагааны бодлогыг баримтлан зохицуулна.

Зураг 4: Арвайхээр хотод төлөвлөгдсөн шугам сүлжээний зураглал



5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон ЮНЕСКО-гоос баталсан олон улсын эрх зүйн актуудад соёлын төрөл зүйл, соёлын өвийг хамгаалахтай холбоотой дараах асуудлуудыг тусгасан байдаг. Үүнд:

- 1972 онд баталсан “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах” тухай конвенц;
- 2001 онд баталсан “Соёлын төрөл зүйлийн тухай” тунхаглалд соёлын өв, түүний төрөл зүйл нь бүх хүн төрөлхтний өв хөрөнгө бөгөөд өнөө үе болон хойч үеийн ашиг сонирхлын үүдснээс тэдгээрийг хүлээн зөвшөөрч, хадгалж хамгаалах тухай заасан байна.

- Монгол улсын Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 7.1-д “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасан.
- Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8-д хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан Дулааны станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна. 27.9-д урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна. 27.10-т урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно гэж заажээ.
- Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байх бөгөөд соёлын биет өвийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ.

Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотын дулаан хангамжийг сайжруулах төслийн талбай нь улсын болон орон нутгийн түүх, соёлын дурсгалт газартай давхцалгүй. Тиймээс тус төслийн үйл ажиллагаанаас түүх, соёлын дурсгалт газарт шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй.

Хүснэгт 5.1: Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Барилгажилтын үед газар шорооны ажил хийгдэх явцад өмнөх судалгаагаар илрээгүй, хөрсөнд хадгалагдан үлдсэн байж болзошгүй археологи, палеонтологи, түүх соёлын дурсгалт зүйлс илэрч, нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгажилтын үед түүх, соёлын дурсгалын зүйлс илэрсэн тохиолдолд ажлыг зогсоож, холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ авах	Дулааны станцын талбай, дулааны дамжуулах төв, дулааны шугам сүлжээ, цахилгааны дэд станц, цахилгаан дамжуулах шугам сүлжээ		-	2023-2024	Соёлын өвийг хамгаалах тухай хууль, 27.8, 27.9, 38.3-р зүйл
Нийт зардал, төг				-		

6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн бүхий л үе шатанд тохиолдож болзошгүй осол, аюул, эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгав.

Осол, аюулыг эх үүсвэрээр нь дараах байдлаар ангилав. Үүнд:

- Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад үүсэх осол,
- Мэргэжлээс шалтгаалах өвчлөл, халдварт өвчин тархалтаас шалтгаалсан осол,
- Байгалийн гамшиг тохиолдох,
- Гал түймэр гарах,
- Хяналтаас гадуурх дэлбэрэлт үүсэх,
- Тээврийн хэрэгслийн осол гарах.

6.1 Баримтлах эрх зүйн баримт бичиг

Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй химийн хорт болон аюултай бодистой холбоотой хууль тогтоомжуудыг биелүүлэх нь хүний эрүүл мэнд байгаль орчин, төслийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Химийн хорт болон аюултай бодистой холбоотой дараах хууль журмуудыг үйл ажиллагаанд мөрдөж ажиллана.

- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль,
- Эрүүгийн хууль,
- Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/,
- Гамшгаас хамгаалах тухай хууль,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль,
- Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт, Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт,
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам, БОАЖСайд, ГХСайдын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 334/104 дүгээр хамтарсан тушаал,
- MNS 6458:2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага,
- MNS 5029:2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг,
- MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах. ААН, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм,
- MNS 4628:2013 Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага,
- MNS 12.104-94 Хөдөлмөр хамгааллын стандартын систем,
- MNS 5105:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага,
- MNS 4747:1999 Химийн технологи. Химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн. Аммиакийн шүү. Техникийн ерөнхий шаардлага.

Дулааны станцыг барьж, ашиглах төслийн 2023 онд хэрэгжүүлэх “Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө”-г дараах хүснэгтэнд нэгтгэн тусгав.

Хүснэгт 6.1: Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгж	Нэгжийн өртөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
Химийн бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, бүх ажилчид хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүдийг ашиглаж хэвших	Химийн бодистой харьцах бүх хүн					Үйл ажиллагааны зардал	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль,
Гал түймэр	<p>1. Дулааны станцын талбайд гал түймрээс сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авах</p> <p>2. Дараах эрсдэл бууруулах арга хэмжээг авах: -Нийт ажилчдыг гал унтраах сургалтад хамруулах, -Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах, -Бүх ажлын талбайд галын дохиолол, аюулын гарцын (хэрэв тодорхой биш бол, жишээ нь ганц хаалгатай бол) байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавьсан байх хэрэгтэй.</p> <p>3. Гал гарсан тохиолдолд: -Галаас яаралтай гарах -Химийн бодистой ажиллахад тэднийг хадгалах бүх зааврыг хатуу дагаж мөрдөх, тэдгээр бодисыг зохих газарт нь хадгалах -Гал түймрийн үед барилга байгууламж бүрт тохирох зааврыг ашиглах</p>	Төслийн бүх байгууламжуудад	Төгрөг	600,000 - гал унтраагуур (дугуйтай)	2	(1,200,000)	Үйл ажиллагааны зардал	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг
				13,000 Гал унтраагуур 1 кг	10	(130,000)		
				95,000 Гал унтраагуур 2-5 кг	10	(950,000)		
Хяналтаас гадуурх дэлбэрэлт	Төслийн талбайд аюулгүй ажиллагааны бүх дүрэм журам болон аюултай бодистой холбоотой бусад бүх журмыг дагаж мөрдөх	Зуухны хэсэг	Төгрөг	-	-	-	Цалингийн зардалд тусгагдсан	Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг
Хүний эрүүл мэнд муудах	Хүний эрүүл мэнд муудахад аймгийн эрүүл мэндийн нэгдсэн төвд хүргэх арга хэмжээг авна.	Төслийн бүх байгууламжуудад	Төгрөг	-	-	-	Үйл ажиллагааны зардал, цалингийн зардалд тусгагдсан	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгж	Нэгжийн өртөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
Автомашин осол	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдөөгүй тохиолдолд авах арга хэмжээний тухай бодлогыг боловсруулж, мөрдөж ажиллах, нэг буюу түүнээс олон автомашин хамарсан осол гарсан тохиолдолд компанийн даатгалын журмыг мөрдөнө. Ослын улмаас хүн бэртэж гэмтэх буюу нас барсан тохиолдолд урьд нь тогтоосон эмнэлгийн түргэн тусламжийн журмыг мөрдөнө. Гал түймэр гарвал галын журмыг мөрдөнө.	Төслийн түүхий эд тээвэрлэлтийн нэгжүүдэд		-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 5 дугаар бүлэг, Замын хөдөлгөөний дүрэм Замын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг
Хэсгийн дүн							-	

7. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) зааснаар дулааны станцын төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгчид өгөгдсөн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон дулааны станцын төслийг хэрэгжүүлэх явцад төсөл хэрэгжүүлэгчээс байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүн, төслийг хэрэгжүүлж буй дэвсгэрт бий болж болзошгүй өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор хяналтын үзүүлэлтүүд, байршил, хийх хугацаа, зардал, баримтлах стандарт, аргачлалыг тодорхойлж энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь төслийн нөлөөллийн болон нөлөөлөлд өртөж болзошгүй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг илтгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

БОМТ болон ОХШХ-ийн хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах.

Дулааны станцын төслийн 2023 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээ, мониторингийн зардал 650,000 төгрөг.

Хүснэгт 7.1: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжигдэхүүний нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн зардал, төгрөг	Нийт зардал, төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Зөвшөөрөгдсөн дээд, доод утга
ГАЗРЫН ГАДАРГА ХЭВЛИЙ									
Газрын гадаргын төрх байдлын өөрчлөлт	Га	Дулааны станцын талбай	5 жилд 1 удаа	5 жилд 1 удаа		-	Хот суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажилд багтаах	Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам	MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заасан үзүүлэлтийг хөрсний шинж чанарт тохируулан харьцуулах
Хэсгийн дүн						-			
ХӨРСӨН БҮРХЭВЧ									
Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд (ялзмаг, хөдөлгөөнт фосфор, хөдөлгөөнт кали, урвалын орчин, цахилгаан дамжуулах чанар, карбонат)	Ялзмаг – хувь, хөдөлгөөнт фосфор – мг/100 г, хөдөлгөөнт кали – мг/100 г, карбонатын агууламж - хувь	Хөрс хуулах талбай	Хөрс хуулахын өмнө	3 удаа	50,000	150,000	Нөхөн сэргээлт хийхийн өмнө үржил шимт хөрсний овоолгоос 0-20 см гүнээс дээжийг авна.	Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990	
Хөрсөн дэх хүнд металлууд Ag, Al, As, B, Ba, Be, Bi, Ca, Cd, Co, Cr, Cu, Fe, Ga, Hg, K, La, Mg, Mn, Mo, Na, Ni, P, Pb, S, Sb, Sc, Sr, Th, Ti, Tl, U, V, W, Zn	мг/кг	Тоосжилт үүсэх эх үүсвэрийн салхины доод хэсэгт агаарын чанарын хяналт шинжилгээний 2 цэгийн ойролцоо	Жилд нэг удаа	1 цэг	100,000	100,000	Хөрсний гадаргын 0-1 см гүнээс авна	Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 2305:1994 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS	

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжигдэхүүний нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн зардал, төгрөг	Нийт зардал, төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Зөвшөөрөгдсөн дээд, доод утга
							5850:2008		
Хэсгийн дүн						800,000			
УРГАМЛАН НӨМРӨГ									
-Ургамлын зүйлийн бүрдэл -Тусгаг бүрхэц -Нэн ховор, ховор, ашигт ургамал ургадаг эсэхийг шалгах -Ургамалжилтын төлөв байдлыг тодорхойлох	%	Хөрс хуулалт хийх талбай	Хөрс хуулалтын өмнө 1удаа	1	400,000	400,000		Ургамлын бичиглэл хийх ерөнхий аргазүй	Арвайхээр хотын дулаан хангамжийг сайжруулах төслийн БОТБУ-ний тайлан, 2019
Хэсгийн дүн, төг						400,000			
Мониторингийн арга хэмжээний нийт зардал						650,000			

8. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Эрчим хүчний яамны захиалгаар хэрэгжиж байгаа Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын дулаан хангамжийг сайжруулах төслийн 2023 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БОАЖЯ)-д хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг ийн эцэст хийнэ.

Энэхүү төлөвлөгөөг “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь”-ийн дагуу оролцогч талуудад тайлагнана.

Хүснэгт 8.1: Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцах эзэн	Зохион байгуулах газар
БОАЖЯ-ны ХБОБНГ-т	"Байгаль менежментийн төлөвлөгөө боловсруулах, батлах, журам"-ын дагуу орчны хянан тайлагнах	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө, Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нутгийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	Төсөл хэрэгжүүлэгчээс тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан харьяа аймгийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг харьяа аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажиллуулан дүгнэлтийг тухайн оны 11 дүгээр сарын 30-ны дотор гаргуулна.	Үйл ажиллагааны зардал (Тухайн жилийн тайлан боловсруулах, хэвлэх ажлын зардал)	Төсөл хэрэгжүүлэгч	БОАЖЯ-ны ХБОБНГ Харьяа аймгийн БО-ны газар
Харьяа сумын ЗДТГ, БО-ны албанд	Танилцуулга, илтгэл болон тайлан гаргаж хурлаар хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал (Тухайн жилийн тайлан, тараах материал хэвлэх болон бусад зардал)	Төсөл хэрэгжүүлэгч	Орон нутгийн ЗДТГ
Иргэдийн төлөөлөл	Орон нутгийн иргэдийн төлөөлөлийг дулааны станцын талбайд хүлээн авч, Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах,	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал (Тухайн жилийн тайлангийн танилцуулга, тараах материал хэвлэх, танилцуулга хийх зардал)	Төсөл хэрэгжүүлэгч	Дулааны станцын талбайд